



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/132

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 19 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах чиглэлээр хүүхэд багачуудын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх арга хэмжээний зардалд 3,493,400 (гурван сая дөрвөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зардалд шаардагдах 3,493,400 (гурван сая дөрвөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4.Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН



Сумын Засаг даргын 2024 оны
6 дугаар сарын 13-ны өдрийн А/132
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХҮҮХЭД БАГАЧУУДЫН МЭДЛЭГ,
ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд багачуудад сургалт сурталчилгааны материал бэлтгэх	90	7,500	675,000
2	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр иргэдэд зориулсан сургалт, зөвлөгөөний зардал	130	21,680	2,818,400
3	Нийт дүн			3,493,400

---oOo---